

СОЁМБОМЭДЭЭ

ЖЕНДЕРИЙН ТЭГШ ЭРХИЙГ ХАНГАХАД АНХААРАХ ТУХАЙ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Батлан хамгаалах яам, “Монголын эмэгтэйчүүдийн сан” ТББ-тай хамтран “Ажлын байрны бэлгийн дарамт, түүнээс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг өчигдөр танхим болон цахим хэлбэрээр хослуулан явууллаа.

Сургалтад ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, БХЯ-ны харьяа байгууллагын төлөөлөл танхимаар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн алба хаагчид цахимаар оролцов. Ингэхдээ жендерийн тэгш оролцоог хангах үүднээс нэг байгууллагаас эрэгтэй, эмэгтэй хоёр цэргийн алба хаагчийг хамтад нь оролцуулсан юм.

Сургалтыг нээж БХЯ-ны СБТГ-ын дарга, Жендерийн салбар зөвлөлийн орлогч дарга, хурандаа С.Ганбямба “Өнөөдрийн бидний ярилцах асуудал маш чухал сэдэв. Хэдийгээр Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин өөрийн гэсэн онцлог, босоо удирдлагын тогтолцоотой, эрэгтэйчүүд зонхилсон бүтэцтэй ч цөөнх болсон эмэгтэйчүүдийнхээ эрх ашгийн төлөө дуугарч байх ёстой. Ялангуяа, ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамтын талаар ойлголт өгч, түүнээс урьдчилан сэргийлэхэд эмэгтэйчүүдийнхээ оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх учиртай.

Мэдээж манай салбарт ажлын байрны бэлгийн дарамт байгаа, байхгүй гэж яриамааргүй байна.

Жендерийн үндэсний хорооны өмнө хүлээсэн үүргийнхээ хүрээнд сургалт, сурталчилгаа явуулж, эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох нь бидний үүрэг. Энэхүү үүргийнхээ хүрээнд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Жендерийн мэдрэмжтэй хөдөлмөрийн дотоод журам”-ын төслийг боловсруулаад байна. Энэхүү журам нь ажлын байрны бэлгийн дарамтад өртсөн алба хаагчийг хамгаалах эрх зүйн баримт бичиг юм. Журам батлагдсанаар БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Зэвсэгт хүчний нэгтгэл ангиуд, БХЯ-ны харьяа байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д ажлын байрны дарамт, хэлбэрүүдээс урьдчилсан сэргийлэх, зөрчигчдөд хэрхэн хариуцлага хүлээлгэх талаар тодорхой тусгуулна” гээд сургалтын үйл ажиллагаанд амжилт хүссэн юм. Ингээд “Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан” ТББ-ын ерөнхийлөгч, доктор Ц.Бүжидмаа “Жендерийн эрх тэгш байдлын тухай ойлголт”, багш Ц.Ундрах “Ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамтын талаарх эрх зүйн орчин”, “Либерал

эмэгтэйчүүдийн оюуны сан”-гийн гүйцэтгэх захирал Г.Дэлгэрсүрэн “Ажлын байрны дарамт, хүчирхийлэл, илрэх хэлбэрүүд” зэрэг сэдвээр илтгэл тавилаа.

Үүний дараа БХЯ-ны СБТГ-ын мэргэжилтэн, ахлах дэслэгч Ц.Хишигсүрэн “Ажлын байрны дарамт, ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх, урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээрх илтгэлдээ ажлын байрны аливаа дарамтаас хамт олноо урьдчилан сэргийлэх нь удирдлагын үүрэг. Жендерийн мэдрэмжтэй бодлого боловсруулж, сургалт сурталчилгааг явуулж, эрэгтэй эмэгтэй цэргийн алба хаагчдын тэгш оролцоог аль болох хангаж байвал тухайн байгууллагад ажлын байрны дарамт харьцангуй бага байдаг. Манай Зэвсэгт хүчний ангиудаас Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн “Хөдөлмөрийн дотоод журам” нь жендерийн мэдрэмжтэй болсон хэмээн онцлоод ажлын байрны дарамтад зөвхөн эмэгтэйчүүд гэлтгүй эрэгтэйчүүд ч өртдөгийг жишээ татан ярилаа.

Төгсгөлд нь ЗХЖШ-ын Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Н.Нямжаргал “Жендерийн мэдрэмжтэй хөдөлмөрийн дотоод журам”-ыг боловсруулах шалтгаан, журмын төсөлд орсон онцлох заалтуудын талаар танилцуулж, эцэслэн батлагдсаны дараа БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, Барилга-инженерийн цэргийн

удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд, Батлан хамгаалах яамны харьяа байгууллагууд “Хөдөлмөрийн дотоод журам”-даа өөрчлөлт оруулж, жендерийн тэгш эрхийн чиглэлээр заалтууд тусгаж оруулна гэсэн юм.

Сургалтыг хааж БХЯ-ны СБТГ-ын дарга, Жендерийн салбар зөвлөлийн орлогч дарга, хурандаа С.Ганбямба “Чухал сэдвээр хуралдсан та бүхэндээ баярлалаа. Хамтран зохион байгуулсан төрийн бус байгууллагууд болон алба хаагчдаа танхимаар болон цахимаар оролцуулсан ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Барилга-



инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын удирдлагад талархал илэрхийлье. Өнөөдрийн сургалт жендерийн тэгш эрхийг хангах чиглэлийн эхлэл юм” гэлээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
12	5

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
34	24

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
28	16

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.442.00	3.484.00
CNY	442.50	446.60
RUB	38.90	40.60
JPY	25.61	26.10
KRW	2.46	2.60

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 6
2021.06.16.
/ЛХАГВА ГАРАГ/

ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН ГУРВАН ХӨХ ХӨХӨГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:
Өнгө зүс сайжирна
Наран ургах, шингэх:
04.52-20.53
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Төрөхүй
Суудал:
Хий

Аргын тооллын 6 сарын 16, Буд гараг. Билгийн тооллын 6, Их морь одтой, хөхөгчин хонь өдөр. Өдрийн наран 4 цаг 52 минутад мандан, 20 цаг 53 минутад жаргана. Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адуус муулах, лус тахих, мал худалдан авах, мал түгээх, хийморийн дарцаг хатаахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өнөө зүс сайжирна.

ОНЫ ШИЛДЭГ ДОНОР ХАМТ ОЛНООР ЗХЖШ ШАЛГАРЛАА

Аливаа хүмүүн өөрийн сайн сайхан сэтгэлийн угаас бусдад цусаа хандивлан эрдэнэт хүний амь насыг аварна гэдэг юутай ч зүйрлэмгүй буянт үйлс юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жил бүр зохион байгуулдаг “Цусны донорын дэлхийн өдөр”-ийг 2004 оноос эхлэн тэмдэглэж ирсэн уламжлалтай. Энэ жилийн хувьд “Цусаа бэлэглэж, цохилох зүрх бүхнийг аваръя” уриаг

дэвшүүлэн аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамжийг бүрдүүлэхэд залуучуудын үүрэг оролцоо чухал болохыг онцолсон бөгөөд Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс Монголын улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахисны үндсэн дээр эл өдөрт зориулсан ёслолын ажиллагааг амжилттай зохион байгуулав.



(Үргэлжлэл нь арын нүүрт)

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

80.733

ЭДГЭРСЭН

57.822

НАС БАРСАН

380/11

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2984 (44)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

363

ЭДГЭРСЭН

2575

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 177,393,225

Эдгэрсэн

Нийт: 161,823,606

Нас барсан

Нийт: 3,837,600



Хүүхдийг
КОРОНАВИРУСТ
ХАЛДВАР (КОВИД-19)-
ААС СЭРГИЙЛЬЕ!

ОНЫ ШИЛДЭГ ДОНОР ХАМТ ОЛНООР ЗХЖШ ШАЛГАРЛАА

(Түрүүч нь нэгдүгээр нүүрт)



Дэлхийн улс орнуудад, түүний дотор манай улсад коронавирусын халдварт өвчин, вакцинжуулалтаас үүдэн цусны донорын тоо цөөрч, цус, цусан бүтээгдэхүүний нөөц багасах хандлагатай байгаатай холбогдуулан дээрх уриаг дэвшүүлэн гурван сарын аяныг явуулахаар төлөвлөжээ. Энэхүү дэлхийн өдөрт зориулсан ёслолын ажиллагааг нэгж Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал, анагаах ухааны доктор, дэд профессор Н.Эрдэнэбаяр хэлсэн үгэндээ “Цусны донорын дэлхийн өдөр”-ийн гол зорилго нь бусдын амь насыг аврахын төлөө халуун цусаа бэлэглэдэг ачтан донорууд, уг үйл ажиллагааг дэмждэг иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагуудын ариун үйлсийг сурталчлах, тэдэнд талархал илэрхийлэх, олон нийтэд алдаршуулах, сайн дурын цусны донорыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний амин чухал хэсэг болох цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийг нэмэгдүүлэхэд оршдог” хэмээв.

Энэ үеэр энэрэнгүй үйлстэн иргэд, хамт олон, байгууллагуудыг шагнаж урамшуулсны дотор энэ оны “Шилдэг донор хамт олон”-

оор Зэвсэгт хүчний Жанжин штаб, “JCI Монгол” ТББ-ын хамт олон шалгарсан бөгөөд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэхүү хүндэт өргөмжлөлийг талархал дүүрэн хүлээн авсан юм. Уг шагналыг гарцуулах явцад Зэвсэгт хүчний Жанжин штабын Эрүүл мэндийн хэлтсийн дарга, хурандаа Т.Сүхбаатар “Цус цуглуулалт бол дан ганц Цус сэлбэлт судлалын үндэсний төвд хамааралтай бусхэн бүхний анхаарах ёстой чухал асуудал юм. Монголд цус, цусан бүтээгдэхүүний хэрэгцээ, шаардлага ямар байгаа, нөөц хэр их байгаад бүх хүн анхаарах ёстой. Цус бол маш чухал бүтээгдэхүүн учраас бид энэ асуудалд их санаа зовниж, жилдээ 2-3 удаа цус цуглуулах арга хэмжээг зохион байгуулдаг. Ингэхдээ цус цуглуулахын ач холбогдол, үр дүнгийн талаар сургалтыг явуулдаг. Би өөрөө мэс заслын эмч учир дусал цус ч хүний амийг аврах их чадалтайг сайн мэднэ. Тиймээс донорууддаа баярлалаа. Та бүхний бэлэглэсэн цус олон хүний амь аварсан гэдэгт итгэлтэй байна” гэсэн юм.

Энд тодруулахад, иргэн хүн цус болон цусны бүрэлдэхүүн хэсгээ 35-аас

дээш удаа хандивласан тохиолдолд хүндэт донорын болзлыг хангадаг ажээ. Тэгвэл 2021 оны байдлаар манай улсад нийт 113 иргэн хүндэт донорын болзлыг хангасан бөгөөд тэдний нэг нь Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн төлөвлөлтийн офицер, хурандаа Ж.Одсүрэн юм. Энэ үеэр түүний сэтгэгдлийг сонсоход “Би 1998 онд БХИС-ийн сонгогч байх үеэсээ цусаа хандивлаж эхэлсэн бөгөөд 2016 оноос хойш энэ үйл хэрэгт тогтмол оролцож байна. Энэ нь нэг удаа цусаа хандивлахад 3 хүний авардаг буянтай үйлс юм. Нөгөө талаар биднээс цус авсны дараа Цус сэлбэлт судлалын үндэсний төвд шинжилгээнд оруулж, эрүүл цус гэдгийг нь баталгаажуулдаг учраас өөрийн эрүүл мэндэд давхар хяналт тавих өндөр ач холбогдолтой. Миний эхнэр ч энэхүү энэрэнгүй үйлсэд нэгддэг бөгөөд энэхүү буянтай ажлаа цаашид ч үргэлжлүүлнэ” гэлээ.

Хурандаа Ж.Одсүрэн өнгөрсөн хугацаанд 35 удаа цусаа хандивласнаар хүндэт донорын болзлыг хангаж 105 хүнд амьдрал бэлэглэсэн байна.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

ЦАХИМ ШУУДАНД

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ “ТУСГАЙ ҮҮРГИЙН БЭЛТГЭЛ” СУРГАЛТЫГ ЯВУУЛАВ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Тус аймгийн цэргийн штаб 2020 оноос цэргийн албыг дүйцүүлэн хаагчдын “Тусгай үүргийн бэлтгэл” сургалтыг энэ оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс 6 дугаар сарын 8-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаанд Цэргийн штабын сургалтын төвд зохион байгуулан явууллаа.

Батлан хамгаалахын сайдын 2018 оны а/211 дугаар тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу “Орон нутгийн хамгаалалт” хичээлийг 14 цаг, “Улсын хил хамгаалалт” хичээлийг 6 цаг, “Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа” хичээлийг 38 цаг, “Хүмүүнлэгийн үйл ажиллагаа” хичээлийг 4 цаг, “Улсын болон орон нутгийн бүтээн байгуулалт” хичээлийг 20 цаг, “Амьд гарах арга ухаан” хичээлийг 14 цагаар төлөвлөсөн ба нийт 6 төрлийн 96 цагийн хичээл сургууль, дадлагыг зохион байгуулсан ба Онцгой байдлын алба, Хилийн цэргийн 0131 дүгээр ангиас мэргэжлийн офицерууд хичээл орж, мэдлэг дадлага олгосон юм.

Сургалтын явцад КОВИД-19 цар тахлын халдвар хамгааллыг мөрдөж, бие бүрэлдэхүүний байрлах байр, хичээлийн танхим, хооллох заалыг аймгийн Эрүүл мэндийн

газартай хамтран ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, сургалтад хамрагдах бүрэлдэхүүнийг 2 дахь тун вакцинжуулалтад бүрэн хамруулан, халдвар хамгааллын дэглэмийг сахиулан, Улсын Онцгой комиссоос гаргасан зөвлөмжийн дагуу санамж бичгүүдийг сургалтын байр, хооллох байр, амрах байр, угаалгын газарт байрлуулан, сургалтын явцад

сургалтад хамрагдсан 28 бэлтгэл үүрэгтнээс хөтөлбөрийн дагуу заасан хичээлүүдээр шалгалт авахад нэгдсэн дүнгээр А-4, В-14, С-7, D-2 буюу сурлагын амжилт 100 хувь, чанар 64.3 хувьтай шалгагдлаа. Мөн Зэвсэгт хүчний 100 жил, аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд аймгийн Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран

амны хаалтыг 2 цаг тутамд солиулж, гарыг ариутган, ариун цэврийг сахиулан, 0,2 хувийн хлорамин уусмалаар ариутгал, чийгтэй цэвэрлэгээг өдөр бүр хийж, өрөө тасалгааны агаар сэлгэлтийг тогтмол хийлгэн зохион байгууллаа.

Сургалтын төгсгөлд

Гурван сайхан хорооллын урд байрлах мод үржүүлгийн 1030 м талбайг хашаажуулж, будаж өнгө үзэмжийг сайжруулан, ногоон битүүмжлэлийн ханган ажиллалаа.

Дэд хурандаа Д.УЛАМБАЯР



ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛД 37 САЛБАРЫН 3200 ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ ОРОЛЦОНО



Ардын хувьсгалын 100 жилийн ой, Монгол Улсын Төрийн далбааны өдрөөр төв талбайд болох Цэргийн ёслолын жагсаалд 37 салбарын 3200 цэргийн алба хаагч оролцоно. Уг жагсаалын нэгдсэн бэлтгэл энэ сарын 11-ний өдрөөс ирэх сарын 9-ний өдрүүдэд хуваарийн дагуу явагдах юм. Өнөө жилийн Цэргийн ёслолын жагсаалд Улаанбаатар цэргийн хүрээний Хүндэт харуул, Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн хөгжмийн сургуулийн бөмбөрчид, Зэвсэгт хүчний Жанжин штабаас нэг, ҮБХИС болон Хуурай замын цэргийн командлал, түүний харьяа нэгтгэл, ангиудаас тус бүр дөрөв, Агаарын цэргийн командлал, түүний харьяа ангиудаас хоёр, Тусгай хүчний цэргийн командлал, түүний харьяа нэгтгэл, ангиудаас гурав, Холбоо, мэдээллийн технологийн хэлтсийн харьяа ангиудаас хоёр, Хил хамгаалахын ерөнхий газраас гурав, Дотоодын цэргийн штабаас болон Онцгой байдлын ерөнхий газраас тус бүр хоёр, Төрийн тусгай хамгаалалтын газраас нэг, Цагдаагийн ерөнхий газраас гурав, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас нэг, Дотоод хэргийн их сургуулиас гурав, нийт 32 үндсэн салбар оролцох юм.



Түүнчлэн Ардын хувьсгалын журамт цэргээс хойших цэргийн гурван үеийн төлөөлөл болсон явган салбар гурав, Аугаа их Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн Цэргийн ёслолын жагсаалд оролцсон салбаруудыг тус тус оролцуулах юм. Мөн Монгол цэргийн гурван үеийн төлөөлөл болсон морьт цэргийн гурван салбар оролцуулахаар төлөвлөж, агт морьдыг Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгаас татаж буй. Цэргийн техникийн ёслолын жагсаалыг жанжин Д.Сүхбаатарын талбайд болон Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн байрлалд дугуйт, гинжит техник гэсэн ялгавартайгаар тус тус зохион байгуулна. Одоогийн байдлаар нэгдсэн бэлтгэлийг Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн байрлалд эхлүүлсэн бөгөөд байлдааны нисдэг тэрэг оролцуулахаар төлөвлөжээ. Энэ жилийн Цэргийн ёслолын жагсаал нь түүхэн ойнүүд давчдаж байгаагийн дээр цэрэг, техникийн ёслолын жагсаалд оролцож байгаа цэргийн алба хаагч, техникийн тоог нэмэгдүүлснээрээ онцлогтой. Үүнээс гадна эмэгтэй цэргийн алба хаагчдын таван салбар оролцож байгаагийн дээр Дотоод хэргийн их сургуулиас анх удаа эмэгтэй салбарын алба хаагчдыг оролцуулах аж.